



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 14 өдөр

Дугаар A/110

Улаанбаатар хот

Г Хорио цээрийн дэглэм тогтоох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.13 дахь заалт, 51 дүгээр зүйл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3, 7.3.4 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.5.1, 15.5.3 дахь заалт, 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай" 225 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 2 дахь хэсэг, 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Хорио цээр хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам", Мал эмнэлгийн ерөнхий газрын 2019 оны A/187 дугаар тушаалаар батлагдсан "Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар", Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 26-1474 дугаар шинжилгээний дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо 335 дугаар гарам, Өлийн амны нутаг дэвсгэрт оршин суугч мал бүхий иргэний малаас "Малын гоц халдварт шүлхий" өвчний сэжигтэй тохиолдол илэрч шинжилгээгээр батлагдсан тул 2026 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Малын гоц халдварт шүлхий өвчнөөр өвчилсөн бусад малаас шинжилгээний дээж авах, лабораторийн шинжилгээнд хамруулах, устгах ажлыг гүйцэтгэх, хорио цээр голомтын бүсэд ажиллах, нийтийн хэв журам сахиулж, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэх мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Хорио цээрийн дэглэм тогтоосон байршилд хариу арга хэмжээг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж ажиллахыг дараах албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

3.1. Хорио цээрийн дэглэмийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангуулан хүч хэрэгслийг зөв хуваарилан оролцуулж, голомтын бүсийн заагт тасралтгүй ажиллагаатай хяналтын цэгийн байршлыг тогтоож, сэжигтэй бүсийн заагт хөдөлгөөнт эргүүл ажиллуулан мал, амьтан, хүн, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих зэргээр хорио цээрийн арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (Д.Хосбаяр)-д;

3.2. Хорио цээрийн дэглэмийн үед мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврын дагуу мал эмнэлгийн цогц арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, халдварт өвчний цагийн байдлын мэдээллээр холбогдох газруудыг ханган ажиллахыг дүүргийн Мал эмнэлгийн тасаг (М.Бүжинлхам)-т;

3.3.Хорио цээрийн дэглэм тогтоосон бүс нутагт зайлшгүй шаардлагаар нэвтрэх хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс бусад шилжилт хөдөлгөөнийг бүрэн зогсоож, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг дүүргийн Цагдаагийн газар (хурандаа Г.Байдраг), хорио цээрийн дэглэм сахиулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг дүүргийн Онцгой байдлын хэлтэс (хурандаа Д.Мөнхсайхан)-т;

3.4.Хорио цээрийн бүс дэх малчин өрх, мал бүхий иргэд, малын тоо, толгой болон холбогдох судалгааг гаргаж, мал бүхий иргэдэд малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон өвчний хор хөнөөлийн талаар ухуулан ойлгуулах, мал сүргээ хариулгатай байлгах, малчдын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, дүүргийн Онцгой комиссын шийдвэрийн талаар мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасаг (С.Мижиддорж), 21 дүгээр хорооны Засаг дарга бөгөөд Жаргалант тосгоны Захирагч (М.Батмэнд)-д;


3.5.Мэргэжлийн анги, багийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа ажилтан, албан хаагч, хорио цээрийн бүс дэх малчид, иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхийг Жаргалант тосгоны Эрүүл мэндийн төв (Г.Батжаргал)-д;

3.6.Хорио цээрийн дэглэмийн бүсэд орсон өрхийн сургууль, цэцэрлэгийн насны хүүхдийн сургалтын тасралтгүй байдлыг хангах арга хэмжээ авч, зохицуулалт хийж ажиллахыг дүүргийн Боловсролын хэлтэс (Б.Бадамханд)-т;

3.7.Хорио цээрийн голомтын бүсэд орсон өрхөд хүнс, бусад шаардагдах дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Сугар)-т.

4.Хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд ажиллах мэргэжлийн анги, багийн албан хаагчдын хоол, унаа, халдвар хамгааллын хувцас болон шаардагдах бусад зардлын тооцоог гарган, зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Бат-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунзаяа)-т тус тус зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (Д.Хөсбаяр) дг даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.БАТТӨР

0023100758
9091904-8-СБТ23271

